

**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Төрийн удирдлагын чиглэлээр:

2022 оны 2 сарын 28-нд 2-р баг, 3 сарын 14-нд 3-р баг, 3 сарын 15-нд 4-р баг тус бүр багийн Иргэдийн нийтийн хурлаа хийж багийн Засаг даргын тайлан, Засаг даргын 2021 оны тайланг ард, иргэдэд танилцуулан, цаг үеийн асуудлаар хэлэлцлээ.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/96 тоот захирамжийн дагуу “Илүүдэл жингүй эртэч Монгол” аяныг хэрэгжүүлэх зорилгоор сумын хэмжээнд албан, байгууллага, аж ахуй нэгжүүдийн дунд болзолт уралдаан зарлаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр:

3-р сарын 3 өдөр сумын төвд хоршооны хөгжил, иргэдийн санаачлага сэдэвт сургалт зөвлөгөөнийг Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт төсөлтөй хамтран сургалт зохион байгуулж уг сургалтанд нийт 120 малчин оролцсон

3-р сарын 12 өдөр Баруун урт хотод "Залуу малчдад мал аж ахуйн зохистой дадлыг эзэмшүүлэх сургалтын тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх" TCP/MON/3806 төслийн хүрээнд сумаас 1-р багийн малчин Х.Өнөрбаяр оролцсон

Сумын нэгдсэн хогийн цэгийг Канав хэсэглүү түрүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн хуучин янзалсан байсан хогийн цэгийн хажууд хаягдсан эзгүй хогийг цэвэрлэж янзалсан.

Хууль бус ашигт малтмал хайгч нинжа нартай тэмцэх эргүүл хяналт шалгалтыг 3 удаа хийж 1 зөрчил илрүүлж аймгийн хуулийн байгууллагад шилжүүлсэн.

3 багийн бор өндөр гэх газарт гарсан хээрийн түймэрт 1 бүрэлдэхүүн ажиллаж цурманд оруулж түймэр тавьсан эзэн холбогдогчдод торгуулийн арга хэмжээг авч нийт 245850 төгрөгний нөхөн төлбөр торгууль тавьсан

Дархан хаан уулан дахь аргаль хонины идээшлэлт нутагшилтанд 3 удаа мониторинг судалгааг хийж уулан дахь хогийг цэвэрлэсэн

Дорнод Монголын хуурай хээрийн төслийн хүрээнд хоршоог хөгжүүлэх сургалт болон Баянцагаан талын тусгай хамгаалалтай газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулах суурь судалгааг ажлын хэсэгтэй тус газарт хийсэн.

Дорнод Монголын хуурай хээрийн төсөл Дэлхийн байгаль хамгаалах сан зэрэг төслийн хүрээнд улсын тусгай хамгаалалтай газрын ач холбогдол болон цагаан хээрийн өнөөгийн нөхцөл байдал зэрэг суурь судалгаанд Дорнод аймгийн Цагаан овоо сумын БНГ тосон хулстай Сүхбаатар сумын Баянцагаан тал зэрэг газруудад 4 хоног судалгааг 250 гаруй иргэнд хийсэн.

Гоц халдварт "Шүлхий" өвчний хязгаарлалтын дэглэмийг 2022.03.14-нд Засаг даргын А/38 тоот захирамжаар цуцалсан.

2022.03.09 нд Аймгийн мал эмнэлгийн газраас Орон нутгийн тарилга вакцин татан ирсэн. Үүнд ДХХ энтеробактериозийн вакцин-194,6л, Цусан халдвартын вакцин 224,2л татан авчирч эмч нарт хувиарлан өгсөн байна. 2022.03.22 нд Монгол ВИ.И.ТИ.НЕТ төрийн бус байгуулгаас суманд ирж сургалт авлаа. Үүнд Мал эмнэлгийн халдварт, паразит, өвчнүүд болон бизнесийн талаар сургалт өгсөн. Мөн малын эмийн худалдаа, сугалаа явуулсан. 2,5 сая

төгрөгний эмийн борлуулалт хөнгөлөлтэй үнээр зарагдсан байна. Сургалтанд 45-н малчид ард иргэд оролцсон болно

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

Хэвтэн эмчлүүлэгч – 38

Ор хоног – 271

Нийт үзлэг- 1244

Идэвхитэй хяналт- 339

Эрт илрүүлгийн үзлэг-177

Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэг 970хүн хамрагдахаас -105 хүн хамрагдсан илэрсэн-1

Чихрийн шижин хэв шинж Эрт илрүүлгийн үзлэг -1250 хүн хамрагдахаас-72 хүн хамрагдсан илэрсэн -2

Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт – 0

Түргэн тусламжийн дуудлага - 40

Алсын дуудлага – 13

Гэрийн дуудлага- 26

Осол гэмтлийн дуудлага - 1

Нас баралт – 1

Ковидын вакцины нэмэлт тунгын хүрээнд дархлаажуулалт 1-р тун 0, хүн 2-р тун 15, хүн 3-р тун 15, хүн 4-р тун 28 хүн тус тус хамрагдсан.

АЗДаргын удирдамжын дагуу “Эрчүүдээ хайрлая” өдөрлөгийг зохион байгуулж аж ахуйн нэгж албан байгууллага иргэдийг хамруулж эрүүл мэндийн төвөөс үзлэг хийж зөвлөгөө өгсөн.

Эмэгтэйчүүдийн баярыг угтан 5-н багийн нийт 177 эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх хөхний үзлэг, саахарын шинжилгээ , эсийн шинжилгээ ,үзлэг оношлогоог хийсэн.

Томуу томуу төст өвчлөл ихэссэнтэй холбоотойгоор Цэцэрлэг, Сургуулийн хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн.

Бага ангиудын эцэг, эхийн зөвлөлийн гишүүдийн дунд сургалт, зөвлөгөөн, АЛТАН ХОНХ тэмцээн зохион явууллаа. Мөн "Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргууд" сэдэвт сургалт хийлээ.

Ааш өсвөр үеийн волейбол-ын тэмцээнд бага насны ангилалд эрэгтэй баг тамирчид хүрэл медаль хүртлээ

ДЭЛХИЙ МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ-2022 аяны хүрээнд "Мөнгөнд ухаалаг хандаж, ирээдүйгээ өөрсдөө бүтээцгээе" уриатайгаар 6-9-р ангид сургалт, “АЛТАН ХОНХ” тэмцээн зохион явууллаа.

Үндэсний их сургуулийн нэрэмжит "Олон хотын ТАЕКВОНДО" -ийн аварга шалгаруулах тэмцээнд 8а ангийн сурагч Т.Мөнхзаяа “Алтан” медаль хүртсэн.

ЕБС-ийн дунд ангийн "Эцэг эх, асран хамгаалагчдын зөвлөгөөн, уулзалт"-д ангиудын төлөөлөл 40 эцэг эх, асран хамгаалагч оролцлоо. Дунд ангийн эцэг, эхийн зөвлөлийг шинэчлэн байгууллаа.

Жудо бөх өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож эмэгтэй баг тамирчид 3-р байр эзэлсэн.

Эрчүүдээ хайрлая аяны хүрээнд өсвөр үеийн сурагчдын дунд урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан СӨБ-ийн Шинэчлэл ТББ-ын тэргүүн Ж.Хорлоо багшийн "Цэгээр наадъя" арга зүйн сургалтанд бүлгийн багш нар бүрэн хамрагдсан.

"Эрчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа" аяны хүрээнд "Эрчүүдээ хайрлая" аянд нэгдэж байгууллагын болон багш, ажилчдынхаа эрчүүдийн судалгаа гаргаж эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан. Мөн эрчүүдээ хайрлая аяны хүрээнд байгууллагынхаа багш, ажилчдын эрчүүдийн дунд хөгжөөнт буухиа тэмцээн зохион явуулсан

Ээлжийн бүлгийн багш Н.Болортуяа зайнаас суралцаж байгаа хүүхдүүддээ гэр бүлийн орчинд хүүхдээ сургуульд ороход нь бэлтгэх зорилгоор "Миний номын өргөө" багцаа хөдөөгийн багийн 20-н хүүхдүүдэд хүргэн ажиллаж байна.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Тогтвортой хөгжлийг дэмжигч Эко сургууль хөтөлбөрт" олон улсын Эко сургууль, цэцэрлэгийн анхан шатны 3-н өдрийн сургалтанд Ж.Өлзийсайхан, С.Золжаргал, Б.Гэрэлтуяа, Э.Нямгэрэл, Б.Хоролсүрэн нар хамрагдсан.

Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран 6-н бүлгийн 110 хүүхдүүдэд тандалын үзлэг хийж өвчтэй хүүхдийг буцааж ажилласан.

Соёл урлагийн чиглэлээр:

"Монголын эх орончдын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэдийн авъяас чадварыг хөгжүүлэх зорилгоор **"ЭХ ОРОН МИНУ"** караоке дууны тэмцээнийг амжилттай зохион байгуулав. Тэмцээнийг сумын Монгол ардын нам 300.000 төгрөгөөр ивээн тэтгэсэн бөгөөд 32 хүнийг хамруулж, танхимаар нийт **115** хүнд толилууллаа.

Улаанбаатар хотын илбэчин, алиалагчдын хамтарсан ЦИРК-ийн тоглолтыг хүүхэд багачуудад толилуулж танхимаар 140 хүнд хүргэсэн.

"ХАМТАРЪЯ, ХӨДӨЛМӨРЛӨЕ, ХӨГЖЬЕ" уриатай Сүхбаатар сумын ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗӨВЛӨГӨӨН-ийг зохион байгуулж, 5 багийн 150 эмэгтэйчүүдийг хамрууллаа. Сумын эмэгтэйчүүд хамтран сумын газрын зургийг эсгийн урлалаар оёж, Орон нутаг судлах музейд хандивласан болно. Мөн зөвлөгөөний үеэр сумын 150 эмэгтэйчүүд нэгдэн "Цахим соёлд суралцаж, Цагаан идээ боловсруулж, буйр хотоо цэвэрлэн, бусдад зөвөөр үлгэрлэцгээе" уриалгыг гаргалаа.

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор "ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН КАРАОКЕ" дууны тэмцээнийг зохион байгуулж, танхимаар 145 хүнд хүргэсэн.

Жил бүр уламжлал болгон зохион явуулдаг "ЭЭЖДЭЭ ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ УРАЛДААН"-ыг 11дэх жилдээ амжилттай зохион явууллаа. Энэхүү уралдааныг хувиараа хөдөлмөр эрхлэгч Г. Болдбаатарын гэр бүл 1.000.000 төгрөгөөр ивээн тэтгэж оролцов. Ээждээ захидал бичээрэй уралдаанд нийт 22 хүнийг хамруулсан болно.

Монгол улсад зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ой "Монгол цэргийн баяр"-ыг тэмдэглэн өнгөрүүлэх, олон нийтийн авъяас чадварыг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулсан "ЭРЧҮҮД ДУУЛЖ БАЙНА" караоке дууны тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. "Эрчүүд дуулж байна" караоке дууны тэмцээнд 7 багийн 28 хүнийг хамруулж, танхимаар 120 хүнд хүрсэн.

Дорнод аймгийн Баян-Уул сумын соёлын төвтэй "СОЁЛ УРЛАГ-ХӨГЖЛИЙН ДАРХЛАА" туршлага солилцох уулзалт амжилттай зохион байгуулагдлаа.

Номын сангийн уншлага үйл ажиллагаа тогтмол хэвийн явагдаж байна. Энэ сард шинэ уншигч 12, ирэгсэд 34 хүн нийт 46 хүнд үйлчилгээ үзүүлсэн. Цахим хэлбэрээр шинэ номын танилцуулга-10, сургамжит өгүүллэг-6, мэдлэгт дусал нэмэр булангаар -12 мэдээлэл, тууж, роман-2 ыг цувралаар нийтлэж уншигчдын эрэлт хэрэгцээг ханган ажилласан.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан шагай няслах, шагай шүүрэх, алаг мэлхий өрөх зэрэг тэмцээнийг зохион байгуулав.

3-р сард Орон нутаг судлах музейг Уулбаян сумын 21 зочдод, Сүхбаатар аймгийн мэргэжлийн хяналтын газрын 25 хүнд, Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 30 хүнд, Дорнод аймгийн Баян-Уул сумын соёлын төвийн 11 хүнд, Аймгийн засаг даргаар ахлуулсан 12 хүнд нийтдээ 78 хүнд үзэж сонирхууллаа.

МЭДЭЭ ГАРГАСАН :Хууль, эрх зүйн мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч:Э.Дэлхийцэцэг

ХЯНАСАН: Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Сүхболд